



МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОРШООЛОГЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО



**Бодит ирээдүй: Залуу үеийг
хөдөө аж ахуйн салбарт татан
оролцуулах нь**

БОДИТ ИРЭЭДҮЙ: ЗАЛУУ ҮЕИЙГ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ ТАТАН ОРОЛЦУУЛАХ НЬ

Өөрийн ирээдүйн талаар ихийг мөрөөдөж, амьдралынхаа замыг зоригтойгоор шийдэх тэр үеийг залуу үе гэдэг. Тэгвэл хөдөө орон нутагт ажилладаг залуучууд ямар нэг байдлаар энэ үеийг үл анзааран өнгөрөөх тохиолдол байдаг. Иймээс хүнд хэцүү нөхцөлд ажиллаж багахан хэмжээний орлого олсноос боломж ихтэй, илүү сонирхолтой хот суурин газар луу эсвэл хилийн чандыг зорих нь илүү ашигтай гэж өнөө үед залуучууд бодох нь их болсон. Тэгвэл залуу үегүйгээр хөдөө аж ахуйн ирээдүй ямаршуухан байх вэ? Фермергүйгээр хоол байхгүй, хоолгүйгээр амьдрал байхгүй.

Энэ удаад бид залуу үеийнхэн яагаад хөдөө аж ахуйн салбарт ажиллах сонирхолгүй байдаг, тэд нарыг энэ салбарт үлдэн ажиллахад ямар санаачилга гаргах, юун дээр анхаарах хэрэгтэй талаар ярилцах болно. Ингэхдээ бид, (а) Агритегтра олон улсын байгууллагаас гаргасан Фермерүүдэд нөлөөлөх, зөвлөгөө өгөх арга хэрэгсэл (ФАКТ)-ийн тусламжтайгаар Азийн фермерүүдийн холбоонд гишүүнчлэлтэй 9 орны 660 орчим хөдөөгийн залуучуудыг хамарсан “Хөдөө аж ахуй дах залуучууд” асуудлын хүрээнд хийгдсэн үндэсний хэмжээний судалгаа; (б) 2014 оны 5-р сард зохион байгуулагдсан 13 орны хөдөө аж ахуйн үндэсний хэмжээний 17 байгууллагын төлөөлөл болсон 30 эрэгтэй 10 эмэгтэй оролцогчийн бүрэлдэхүүнтэй бүсийн хэмжээний зөвлөлдөх уулзалтын үр дүн; (в) бусад судалгааны үр дүн дээр үндэслэн хэлэлцэх

болно. Эдгээр зөвлөлдөх уулзалтуудыг Азийн фермерүүдийн холбоо Өрхийн аж ахуйн олон улсын жилийг тэмдэглэн өнгөрүүлэх жилийн хүрээнд удирдан зохион байгуулсан билээ. Учир нь, хөдөө аж ахуй дах залуучууд нь Өрхийн аж ахуйн олон улсын жилийн нэг чухал сэдэв байсан юм.

ЗАЛУУЧУУД ГЭЖ ХЭН БЭ?

НҮБ-ын тодорхойлсноор 15- аас 24 хүртэл насыг залуу үе гэх бөгөөд одоогийн байдлаар түүхэн дэх хамгийн өндөр тооны хүн амьг эзлэж байна. 2012 оны байдлаар дэлхийн нийт хүн амын 18-н хувь буюу 1.8 тэрбум гаруй залуучууд байдаг тоо гарсан байна. Үүнээс 90 хувь нь хөгжиж буй улс орнуудад амьдарч байгаа бөгөөд өөрийн орны нийт хүн амын 20 хүртэлх хувийг бүрдүүлдэг байна.

НҮБ-ын Ази-Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн хорооноос гаргасан судалгаагаар дэлхийн залуучуудын 60 гаруй хувь буюу 750 сая нь Ази-Номхон далайн бүсэд амьдардаг байна. 2010 онд, Энэтхэг улсад нийт хүн амын 19 хувь буюу 234 сая залуучууд бүртгэгдсэн нь дэлхийн хамгийн их залуучуудтай улсаар, 2-рт нийт хүн амын 17 хувь буюу 225 сая залуучууд бүртгэгдсэн Хятад улс тодорсон байна. Япон улсын хүн амын 10 хувь буюу 12 сая залуучуудтай, Филиппин, Бангладеш улсын хүн амын 20 хувийг залуучууд бүрдүүлдэг гэсэн тоо баримт байна.

Олон улс оронд залуу үеийг өөрийн орны нийгэм, соёл, эдийн засгийн байдлын онцлогоос хамаарч янз бүрээр тодорхойлсон



байдаг. Тухайлбал, Тайвань улсад хуулиараа 12-24 насыг, Киргистанд 14-28, Тайланд улсад 15-25, Филиппин Камбож, Вьетнам болон Индонез улсуудад 15/16-30, Монгол улсад 15-34, Непал, Бирм улсуудад 15-40, Бангладеш улсад 18-35, БНСУ-д 9-24, Япон улсад 0-30 насыг залуу үе гэж тооцдог байна.

ХӨДӨӨ ОРОН НУТАГ ДАХ ЗАЛУУЧУУД

Сахарын Африк болон Ази тивийн залуучуудын 70 хүртэл хувь нь хөдөө орон нутагт амьдардаг бөгөөд тэдгээрийн тал гаруй хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажилладаг.□

Олон арван жилийн турш хөдөөгийн залуучууд засгийн газрын болон орон нутгийн засаг захиргаа, олон улсын байгууллагуудын анхаарлын төвөөс гадуур байсан нь хөдөө аж ахуйн салбарт залуучуудын хүч бололцоог бүрэн дайчлах боломжийг үгүй хийсэн юм. Хөдөөгийн залуус гол төлөв ажилгүй, эсвэл бага хэмжээний буюу тогтсон цалингүй, ур чадвар шаарддаггүй, аюулгүй ажиллагааг хангаагүй, хортой нөхцөлтэй ажлын байранд ажилладаг байна. Эдгээр байдлаас болоод хөдөөгийн залуучууд хот суурин газар луу шилжих нь их байдаг. Иймээс ч хөдөө орон нутагт аж ахуй эрхэлдэг хүмүүсийн хүүхдүүд эцэг эх шигээ аж ахуй эрхлэн орон нутагтаа үлдэх дургүй байдаг бөгөөд хөдөө орон нутагт үлдэн ажиллаж байгаа залуучуудын ихэнх нь хүчээр, эсвэл ямар нэгэн өөр сонголтгүй болсон байдаг байна. Энэ байдал нь өөр нэг сөрөг үр дагаварт хүргэж байгаа бөгөөд энэ нь хөдөө аж ахуйн салбарт ажиллагсадын Насжилт юм. Хэрэв залуучууд манай хойч ирээдүй юм бол хөдөөгийн залуучууд бол манай хөдөө орон нутгийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарын ирээдүй юм. Иймээс бид, тэдгээрийг хөдөө орон нутагт нь үлдээж ажиллуулахын тулд юу хийх ёстой вэ? Залуучуудад хөдөө аж ахуйн салбар, үйлдвэрлэлийг сонгосноор сайхан ирээдүй хүлээж байгаа гэдгийг ойлгуулахын тулд ямар бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгтэй вэ?

ЯАГААД ХӨДӨӨ АЖ АХУЙ ЗАЛУУЧУУДЫГ ТАТАХГҮЙ БАЙНА ВЭ?

Азийн фермерүүдийн гишүүн байгууллагуудын залуу удирдагч нарын дунд зохион байгуулсан үндэсний болон бүсийн хэмжээний зөвлөлдөх уулзалтын үр дүн болон бусад судалгаан дээр үндэслэн залуучууд яагаад хөдөө аж ахуйн салбарыг сонирхдоггүй

талаарх харилцан уялдаа бүхий доорх долоон шалтгааныг гаргалаа. Үүнд:

- 1. Фермерүүдийн нийгэмд эзлэх нэр хүнд бага.** Газар тариалан мал аж ахуй эрхлэх нь ур чадвар бага шаардсан, биеийн хүчны хүнд хэцүү ажил бөгөөд, нэр хүнд болон бахархах зүйл багатай гэдэг ойлголт нийгэмд бий болсон. Малчид, тариаланчид өөрсдийн үр хүүхдүүддээ: “Над шиг муу малчин битгий болоорой”, “Хэрвээ чи сайн сурахгүй бол энд үлдэж газар шорооны ажил хийнэ шүү”, “Чи муу сураад байгаа учраас сургуулиа орхиж талбай дээр очиж төмс тарь” гэх мэтээр хэлдэг. Ихэнх хүүхдүүд эмч, инженер, хуульч болохыг мөрөөддөг бол багахан хэсэг нь л фермер болно гэж боддог байна. Хөгжиж буй улс орнуудад хөдөө аж ахуйд ажиллагсад болон тариачид ихэвчлэн доогуур үнэлгээтэй байдаг бөгөөд боловсролгүй бүдүүлэг гэж тодорхойлогддог. (Shrestha, 2001:114-115).
- 2. Газар тариалан мал аж ахуй эрхлэх нь ашигтай ажил биш.** Малчид тариаланчдын ихэнх нь ядуу байдаг. Тэд нар хөдөө аж ахуйгаас хувийн болон өрхийн хэрэгцээгээ хангах хэмжээний хангалттай орлого олдоггүй. Мөн, хөдөө аж ахуйн салбарт ажиллах хүчний өртөг өсөж үр, бордоо, хортон шавьж устгалын үнэ нэмэгдсэн, бүтээгдэхүүний борлуулалт зах зээлээс хараат, үнэ бага, цаг уурын урьдчилан тааварлах боломжгүй нөхцөлөөс шалтгаалсан хөдөө аж ахуйн эрсдэл, үнийн тогтворгүй байдал зэргээс шалтгаалан орлогын хэмжээ байнга буурч байгаа нь залуучуудыг хөдөө аж ахуйн салбараас хөндийрүүлж байна. Түүнчлэн, амьжиргаагаа залгуулах төдий аж ахуй эрхлэх нь залуучуудын хөдөө аж ахуй эрхлэх сонирхлыг татахгүй байна. Аж ахуй эрхлэх нь зөвхөн өрхийн хэрэгцээг хангах төдий байгаа тул залуучууд хөдөө аж ахуйд ирээдүйг олж харахгүй байна.
- 3. Газар эзэмших баталгаа болон газрын үнийн өсөлт.** Жижиг хэмжээний газар тариалан эрхлэлтээс том луу шилжсэн зах зээлд захирагдсан газрын шинэчлэл 1990 оноос эхлэн явагдаж дэлхий нийт энэ хандлага руу шилжиж байна. Эдийн засгийн тусгай бүсийн хотжуулах олон төрлийн хувьчлал нь газрыг зах зээлд чөлөөтэй худалдаагддаг бараа мэт үзэх болсон. (Borras, 2006: 99), (Kumar, 2011).

Зах зээлд тохируулсан газар, хөдөө аж ахуйн шинэчлэлээс шалтгаалж газрын үнэ нэмэгдэж байна. Тариаланчдын амьдрал бие даасан байдлаа алдаж эрх баригч ангиас хамраалтай болсон. Өөрөөр хэлбэл газар нь хэн нэгний эд бараа болж худалдан авах, зарах, ашиг олох арга хэрэгсэл болж хувирсан (Hu, Yeh, Wu, 2009). Ингэснээр газар тариалан эрхлэгчид нь газар өмчлөх эрхээ хасуулж, газрыг өмчлөгчид нь газрыг тариалангийн бус зориулалтаар ашиглах болсон юм. Газрыг тариалан эрхлэгчдээс хураан авч, хувийн өмчлөлд ялангуяа газрын наймаачид, үйлдвэрийн эздийн өмчлөлд шилжүүлж байгаа нь залуучуудыг газар тариалан эрхлэхээс татгалзахад хүргэж байгаа бас нэг шалтгаан болж байна (Kumar, 2011). Одоогийн хийгдэж байгаа газрын шинэчлэл нь хөдөө аж ахуйг шинэчлэхээсээ илүү аж ахуй эрхлэгч залуучууд, тариаланчдын газар эзэмших эрх, тариалангийн талбайг устгаж үгүй хийж байна.

4. Хөдөө орон нутаг дах дэд бүтцийн доголдол. Хөдөө аж ахуйн гол төв бол хөдөө орон нутаг. Гэсэн хэдий ч хөдөө орон нутгийн дэд бүтэц сум хөгжсөн, орчин нөхцөл муу тул тэдний хөдөө амьдрах залуучуудыг татах орон нутагт ажиллах сонирхлыг бууруулж байна. Хөгжиж буй орнуудын хөдөө орон нутаг ихэнхдээ зам харилцаа муутай, цахилгааны саатал их, эмнэлэг, эрүүл мэндийн төв, их дээд болон дунд сургууль, үзвэр үйлчилгээ хомс, интернет сүлжээ байхгүй, хувийн бизнес болон хөдөө аж ахуйн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх боломж бага, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн борлуулах зах зээл байхгүй байдаг.

5. Өрхийн аж ахуй эрхлэгчдийг дэмжсэн засгийн газрын бодлого, хөтөлбөрүүд хомс. Ихэнх хөгжиж буй орны засгийн газар өрхийн аж ахуйгаас илүүтэйгээр аж ахуйн нэгжийг газар тариалан эрхлэхийг дэмжиж байна. Ази тивийн төдийгүй тухайн орны мал аж ахуй газар тариалан эрхлэгчдийн дийлэнхийг бүрдүүлж байгаа өрхийн аж ахуй эрхлэгчдийг дэмжсэн хөдөө аж ахуйн бодлого, хөтөлбөрүүд хангалтгүй байна. Иймээс ч олонх газар тариалан мал аж ахуй эрхлэгчдэд газар, санхүү зээл, зах зээлийн хомсдолтой байна. Арилжааны банкууд болон зээл албан ёсны тогтолцоо аж ахуйн нэгжийг дэмжиж тариаланчид болон өрхийн

аж ахуй эрхлэгчдийн эдийн засгийг уналтанд оруулж зах зээлийн эдийн засгийг бий болгожээ. (Harvey, 2003:156-166). Хөдөө аж ахуйн түүхий эд бүтээгдэхүүний үнэ төрийн болон тариаланчдын хяналтаас гарч зах зээлээс шууд хамраалтай болсон. Ингэснээр худалдааны гэрээ, бодлогын зохицуулалт, үнийн тогтолцооны ил тод байдал алдагдаж байна.(Ahmad et al, 2010:37). Мөн, хөдөө аж ахуйд хамааралтай гол шийдвэр гаргах үйл явцад хөдөө аж ахуй эрхлэгчид оролцон үзэл бодлоо илэрхийлж чадахгүй байгаа төдийгүй, хөдөө орон нутгийн залуучууд болон малчин, тариаланч залуучуудын хэрэгцээнд нийцсэн бодлого хөтөлбөр, тэд нарын гаргасан шинэ санал санаачлагыг дэмжсэн урамшуулал хомс байна. Эдгээр хэрэгцээтэй дэмжлэг тусалцаагүйгээр залуучууд томоохон хэмжээний аж ахуй эрхлэгчидтэй өрсөлдөх чадваргүй юм.

6. Газар болон хөдөө аж ахуйн шинэчлэлийн талаарх төлөвлөлтийн хомсдол. Хөгжиж буй улс орнуудын хувьд хөдөө аж ахуй ажлын байрны гол нөөц юм. Гэвч эдгээр улс орнуудын их дээд болон дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт газрын болон хөдөө аж ахуйн талаар тусгагдаагүй байдаг. Ингэж газар болон хөдөө аж ахуйн шинэчлэлийг үл хайхарснаас залуучуудыг хөдөө аж ахуйн салбарын ажил мэргэжилтэй болох сонирхолгүй болгодог.

7. Газар тариалан, мал аж ахуй эрхлэгч залуучуудын байгууллагын хэрэгцээ. Орон нутаг, үндэсний төдийгүй олон улсын хэмжээнд аж ахуй эрхлэгч залуучууд санал бодол туршилгаа хуваалцах, бие биенийхээ хичээл зүтгэлийг дэмжих, шийдвэр гаргалтын түвшинд өөрсдийн сонирхлыг илэрхийлэх зорилгоор эв санаагаа нэгтгэн зохион байгуулсан байгууллага цөөн байдаг.

АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ ЗАЛУУЧУУДАД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТУУД

Хөдөө аж ахуй, газар тариалан эрхэлж байгаа залуучууд янз бүрийн сорилтуудтай тулгарч байна. Тухайлбал:

1. Бүтээгдэхүүний нөөц(газар, хөрөнгө)-д тавих хяналт болон зах зээлд нэвтрэх боломж дутмаг.

Юуны түрүүнд Азийн ихэнх орнуудад аж ахуй эрхлэгч залуучуудад хандсан газрын

болон хөдөө аж ахуйн шинэчлэлийн бодлого байдаггүй. Ингэснээр тэдний уламжлалт газар тариалан эрхлэлтийг эдийн засгийн эргэлтэнд оруулж газар өмчлөх боломж хаагддаг бөгөөд залуучуудад газар өмчлөх эрх байхгүй учраас голдуу улирлын чанартай хөдөө аж ахуйн хөдөлмөр эрхэлж байна. Хоёрдугаарт, ихэнх залуучууд эцэг эхээсээ газар өмчлөх эрх өвлөгдөн ирэхийг хүлээх ёстой болдог. Эцэг эхтэйгээ хамт аж ахуй эрхлэхэд тэдэнд ямар нэгэн шийдвэр гаргахад оролцох боломж бараг байдаггүй байна. Гуравдугаарт, банк санхүүгийн байгууллагууд хөдөө аж ахуйн салбарт үйлчилгээ бараг үзүүлдэггүй ба, үзүүлсэн ч аж ахуй эрхлэгч залуучуудад хэрэгцээг хангахгүй байна. Дөрөвдүгээрт, олонх аж ахуй эрхлэгч залуучууд бараа бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлээ бий болгож хараахан чадаагүй байна.

2. **Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, борлуулалт бизнес эрхлэх, мэдлэг, ур чадвар хангалтгүй**
Одоогийн залуучууд манлайлал, удирдан зохион байгуулах чадвар болон хөдөө аж ахуйн талаар хангалтгүй мэдлэг, ур чадвартай байна. (PIED, 2012:31). Ур чадварын хөгжил болон технологийн шинэчлэл нь “залуучуудын загвар аж ахуй эрхлэх” гол цөм нь юм. Гэсэн хэдий ч энэ нь засгийн газрын хөтөлбөр болон сургуулийн

сургалтын хөтөлбөр тусгагдаагүй байна. Залуучууд шинэ технологийг илүүд үзэж сонирхдог боловч олон байгууллага тэд нарын хүсэл эрмэлзлэлийг ойлгодоггүй. Иймээс, залуучуудад технологийн болон орчин үеийн аж ахуй эрхлэлтийн талаарх хангалттай мэдлэг, ур чадвар олж авахад нь дэмжлэг туслалцаа, урам зориг өгдөггүйгээс залуучууд хөдөө аж ахуйн салбарт ирээдүйг олж харахгүй байна. (Wobst, 2010).

3. **Даяарчлал, тодорхой бус байдал болон үнийн хувьсгал.**

Азийн зарим орнуудад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн тариф буюу бага, нээлттэй тогтолцооноос болж аж ахуй эрхлэгч залуучууд өөрсдийн бүтээгдэхүүнээрээ өрсөлдөх боломжгүй болж аж ахуйгаа хүчээр орхих тохиолдол байдаг. Мөн үнийн тогтвортой бус байдал нь үүний бас нэг шалтгаан юм. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн бага үнэлгээтэй байх, эсвэл тогтоосон үнэлгээгүй байх нь гаднаас орж ирж байгаа бүтээгдэхүүн хямд, дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үнэтэй мэт ойлголтыг төрүүлснээр хүмүүс хямд үнэтэйг нь худалдан авдаг. Төрөл бүрийн чөлөөт худалдааны гэрээнээс болж жижиг хэмжээний зарим аж ахуй эрхлэгч нар алдагдалд орж хөдөө аж ахуйн мэргэжлээ хүчээр орхих байдалд хүрдэг.



ЗАЛУУЧУУДЫГ АЖ АХУЙ ЭРХЛЭХЭД ТАТАН ОРОЛЦУУЛАХ САНААЧЛАГУУД

1. Манлайллын хөгжил ба чадавхийг бэхжүүлэх.

Өнгөрсөн таван жилд буюу дэлхийд нүүрлэсэн хүнсний хомсдлын үеэр Азийн фермерүүдийн холбоо түүний хамтрагчид, иргэний нийгмийн байгууллагууд, НҮБ-ын агенлагуудаас аж ахуй эрхлэгчдийн холбоо/байгууллага, аж ахуй эрхлэгчид ялангуяа хөдөө орон нутаг дах залуучуудыг хамарсан

тэдгээрийн манлайллын хөгжил, чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж эхэлсэн. Зарим орнуудад манлайллын хөгжил, чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсний дагуу аж ахуй эрхлэгчдийн чуулга уулзалтууд зохион байгуулагдсан. Мөн, хоорондын туршлага, мэдлэгээ солилцох зорилгоор аж ахуй эрхлэгчдийн солилцооны хөтөлбөр хэрэгжиж байна.

Хүснэгт 1: Японы органик аж ахуй эрхлэгч залуучууд

2013 онд Япон улсын органик аж ахуйг шинээр эрхлэгч зургаан залуу жилд дунджаар 8,860 иений ашиг олж байсан бол энэ нь 207 хувиар өссөн байна. Тэдгээрийн энэ амжилтанд хүрэхэд байр, газар, ур чадвар, борлуулалтын зах зээл зэргээр гол тусалцаа үзүүлж байсан хүмүүс бол хөдөө аж ахуйн сургагч багш нар байсан юм. Шинэ залуу аж ахуй эрхлэгчид ньорон нутгийн нэвтрүүлэх үйлчилгээ хариуцсан мэргэжилтэнгүүд, ахмад настан болонойролцоох орон нутгийн аж ахуй эрхлэгч нараас суралцах, сургалтанд хамрагдах, цахим мэдээлэл болон ном сонин унших гэх мэт өөрсдийн хөдөө аж ахуйн талаарх мэдлэгийг олж авсан байна. Эдгээр залуучууд удалгүй биеэ дааснаас гадна, шинээр аж ахуй эрхлэгч залуучуудад зааж зөвлөгөө өгсөн байна. Мөн, хамтын ажиллагаагаа бэхжүүлж гурван томоохон органик хөдөө аж ахуйн бүлгүүдийн дэмжлэгтэйгээр зохион байгуулалтаа нэмэгдүүлсэн байна. Тэд өөрсдийн үйлчлүүлэгчдээ а)найз нөхөд, бүтээгдэхүүнээ тээвэрлэгчид, ахмад тариаланчдаараа дамжуулан олж авах; б) өөрсдөө хайж олох; в) цахимаар гэсэн гурван гол аргыг хэрэглэсэн байна.

Хүснэгт 2: Тайваний Тайнан хот-Шинээр аж ахуй эрхлэгч хөтөлбөр

Энэ хөтөлбөрт аж ахуй эрхлэгчид, аж ахуй эрхлэхийг хүсэгч 45-аас доош насны 2686 (14% нь эмэгтэйчүүд) залуучууд бүртгүүлээд байна. Эдгээр залуучуудад засгийн газрын нэвтрүүлэх үйлчилгээний нэгж техникийн болон санхүүгийн туслалцаа үзүүлж байна. Техникийн дэмжлэгийг шинжээч, дадлагажуулагч, хөдөө аж ахуй хичээл болон зөвлөгөө өгөх тогтолцоогоор дамжуулан үзүүлж байна. Аж ахуй эрхлэгч залуучуудад хөдөө аж ахуйн талаар зааж сургах шинжээч, багш нарыг орон нутгийн хөдөө аж ахуйн холбоодоор дамжуулан гаргасан байна. Аж ахуй эрхлэгч залуучууд тоног төхөөрөмж худалдан авах зэрэгт санхүүгийн дэмжлэгийг үзүүлэхдээ засгийн газрын бага хүүтэй зээлийн хэлбэрээр үзүүлж байна. Ингэснээр олон залуучууд амжилт гаргаж, саятан аж ахуй эрхлэгч болон, органик будаа, органик улаан лооль тариалалтын тэмцээнд түрүүлсэн байна.

2. Өрхийн аж ахуйн талаарх маргаан.

Олон улсын хамтарсан компаниудын хүн амын шилжилт хөдөлгөөн, газрын маргаан болон газар тариалан эрхлэгч томоохон аж ахуй нэгжээс шалтгаалан өрхийн аж ахуй, тариланчдын аж ахуйн талаар маргаан нэмэгдээд байгаа билээ. 2014 онд ихэнх аж ахуй эрхлэгчдийн холбоо/байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, засгийн газрын агентлагуудын дэмжлэгтэйгээр Өрхийн аж ахуйн олон улсын жилийг НҮБ-аас тэмдэглэн өнгөрүүлсэн. Хөдөө аж ахуйн болон хүнсний үйлдвэрлэлтэй холбоотой аж ахуй эрхлэгчдийн холбоо/байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд өрхийн

аж ахуйн талаарх бодлого, тогтвортой, агро-экологийн арга барил, өрхийн аж ахуйн эрхлэгчдийн зах зээлийн өрсөлдөх чадварын талаар хэлэлцүүлэг, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан. Өрхийн аж ахуйд ач холбогдол өгснөөр хөдөө аж ахуй дах залуучуудад онцгой анхаарал хандуулсан юм.

3. Агро-экологийн, тогтвортой, органик аж ахуйг хөгжүүлэх.

Эрүүл амьдралын хэв маягийн дагуу хүмүүс органик хоол хүнсийг сонгох болсон. Үүний үр дүнд органик аж ахуйн тоо нэмэгдсэн байна. Үүний сайн тал нь залуучууд органик аж

ахуйг дэмжих хөтөлбөрт хамрагдаж, тэд нарыг аж ахуй эрхлэх сонирхол нэмэгдэж байна. Тэд нарын хувьд органик аж ахуй нь тэдний ажилд зарим нэг зорилгийг бий болгож, шинийг олж нээх, бүтээх, хуучны болон орчин үеийн аж ахуй эрхлэх аргаас суралцах илүү их боломжийг олгож байгаа юм. Зарим орны засгийн газраас

агро-экологийн, тогтвортой, органик аж ахуйг хөгжүүлэхийг дэмжиж байгаа явдал нь олон залуусыг хөдөө аж ахуйд татан оролцуулж байна. Өмнөд Азид цагаачид Гулф-аас буцан ирж дахин аж ахуй эрхлэх болсон ба тэдгээрийн зарим нь органик аж ахуй эрхлэхийг дэмжин ажиллаж байна.

Хүснэгт 3: Ана Сибаян

Филиппин улсын Миндоро Ориентал-ын аж ахуй эрхлэгч гэр бүлийн 24 настай охиныг Ана гэдэг. Ана нийтийн хоолны тогоочийн дамжаа төгссөн боловч тэрээр аж ахуйн бизнес эрхэлж хувьдаа аж ахуйтай түүнийгээ өөрөө хөтлөн явуулах хүсэлтэй.

Ана Филиппин улсын аж ахуй эрхлэгчдийн үндэсний холбоо болох PAKISAMA-аас зохион байгуулдаг Олон төрөлт органик аж ахуйн нэгдсэн тогтолцоо сургалтанд хамрагдлаа. Энэхүү сургалтанд хамрагдсныхаа дараа буюу 2014 онд Ана гэр бүлийнхээ эзэмшдэг 2,500 м² талбайгаа олон төрөлт органик аж ахуйн нэгдсэн тогтолцоо болгохоор шийдэж гэрийнхнийгээ ятгалаа. Ана гэрийнхээ тариалангийн талбайн хавтгай дөрвөлжин метр бүрт зохистой хэрэглэх хуваарилалт хийж ялзмаг бордоо, загасны цөөрөм, хүнсний ногооны талбай байгуулж, органик тахиагаа нэмэгдүүлэн өсгөлөө.

Одоо тэрээр олон төрөлт органик аж ахуйн нэгдсэн тогтолцоог дэмжиж хөрш зэргэлдээ болон бусад аж ахуй эрхлэгч залуучуудад заавар зөвөлгөө өгдөг болсон байна. Өрхийн аж ахуйн олон улсын жилийг Филиппин улсад тэмдэглэн өнгөрүүлэх үеэр Ана үлгэр жишээ аж ахуй эрхлэгчдийн нэг болон шалгарсан байна.

4. Аж ахуй эрхлэгчдийн холбоо/байгууллагыг байгуулах. Иргэний нийгмийн байгууллагууд болон НҮБ-ын агентлагуудаас аж ахуй эрхлэгчдийн холбоо/байгууллагыг байгуулахад дэмжлэг үзүүлж аж ахуй эрхлэлтийг болон бодлогын

өөрчлөлт хийхээр тэдгээрийг дайчилж байна. Аж ахуй эрхлэгчдийн холбоо/байгууллага нь өөрсдийн залуу үеэ бэлтгэж эхлээд байна. Хэлэлцүүлэг, маргааны гол сэдэв нь аж ахуй эрхлэгчдийн эрх ашиг, шинэ санал санаачилга болоод байна.

Хүснэгт 4: Монголын залуучуудын байгууллагууд

Монголын хамгийн том төрийн бус байгууллаг болох Монголын залуучуудын холбоо зэрэг хэд хэдэн төрийн бус байгууллагууд залуучуудтай холбоотой асуудлыг эрхэлж байна. Энэхүү байгууллага нь залуучуудын хөгжил дэвшлийн төлөөх дуу хоолой болж тэдгээрийн эрх ашгийг хамгаалах зорилготой юм. Залуу малчдын сонирхлыг хамгаалах зорилгоор Монголын залуу малчдын хороо 2013 он байгуулагдсан байна. Энэ хороо 2014 оны 2-р сард Монголын 21 аймгаас ирсэн залуу малчдыг хамарсан үндэсний хэмжээний зөвөлгөөнийг зохион байгуулж, түүндэсний түвшинд явуулсан залуу малчдын талаарх судалгаан дээр ажиллаж байна. 2010 онд Залуу хоршоологч клуб байгуулагдаж 2013 онд хөдөө аж ахуй дах залуу манлайлагч нарын анхны зөвөлгөөнийг амжилттай зохион байгуулсан байна.

Хүснэгт 5: Камбожийн залуучуудын хороо

Камбожийн аж эрхлэгч ба цэвэр байгаль холбоо залуучуудын хороо байгуулж удирдах зөвлөлдөө төлөөгчийг нь оруулсан байна. Мөн аж ахуй эрхлэгч залуучууд малын бууц ашиглан бордоо бэлдэх, мал өсгөх, олон төрөлт аж ахуй байгуулах, органик будаа тарих, загасны цөөрөм байгуулах гэх мэт аж ахуй эрхлэх шилдэг туршлагауудыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа өргөтгөн аж ахуй эрхлэн залуу удирдагч болж өөрсдийгөө хөгжүүлж байна.

5. Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих. Хөдөө орон нутгийн эрчүүд олноороо хот руу шилжих, хилийн чанадыг зорих болсноор хөдөө аж ахуйн салбар

эмэгтэйчүүдийн салбар болж, аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эрх, тэдгээрийн газар өмчлөх эрхийн талаар маргаан эхэлсэн. Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн өөрсдийн

эрх ашгийг хамгаалахаар идэвхитэй зүтгэж байна. Непал зэрэг зарим орнуудад аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн чулган зохион байгуулагдсан байна.

6. Фермерүүдэд зориулсан цогц бодлогод бодит нөхцөлд тулгуурлан нөлөөлөх

Индонез, Филиппин, Непал, Энэтхэг зэрэг орнуудын фермерүүдийн байгууллагууд нь газар эзэмшигч, ХАА-н бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх, газрын удирдлага, газар ашиглалтын хэрэгжүүлэлт, хяналт болон фермерүүдийн эрхийн талаарх бодлого зэрэг олон асуудлуудыг багтаасан газар ба газар тариалангийн шинэчлэлийн бодлогын талаар олон удаагийн цуврал хэлэлцүүлэг, уулзалтуудыг зохион байгуулж байна.

Энэ үйл ажиллагаанд фермерийн байгууллагууд болон Иргэний нийгмийн байгууллагууд идэвхитэй оролцож байна. Фермерүүд газар тариалангийн шинэчлэлийн бодлогод нөлөөлөхөд залуу фермерүүдээ төлөөлөн идэвхтэй оролцож байна. Непал, Монгол, Камбожи, Филиппин, Индонез, Бангладеш, Вьетнам зэрэг орнуудын фермерийн болон иргэний нийгмийн байгууллагууд судалгаа хийж баримт цуглуулсан залуу фермерүүдэд зориулсан бодлогын баримт бичигт тусгуулахаар ажиллаж байна. Тэд судалгааны үр дүнгээ нэгтгэн өөр өөрийн орны Засгийн газар, бодлого боловсруулагч нарт нөлөөлөхөөр ажиллаж байна.

Олон улсын ТББ-ууд болон хүмүүнлэгийн байгууллагуудын ХАА-д хийх хөрөнгө оруулалт, залуу фермерүүдийг дэмжих тал дээр тодорхой ахиц гарсаар байна.

Вох 6. Солонгосын залуу фермерүүд

Солонгосын эрчимжсэн фермерүүдийн холбоо /KAFF/, Эрчимжсэн эмэгтэй фермерүүдийн холбоо /WAFF/-дын хувьд олон бэрхшээлтэй асуудлууд байгаа ч Солонгосын Засгийн газраас газар эзэмшлийн асуудлыг шийдэхдээ хөдөөд 5 жилийн туршид газар тариалан эрхэлсэн хүмүүст газрыг эзэмшүүлэхээр шийдвэрлэжээ. фермерүүдийн хэрэгцээг тодорхойлох тулд Солонгосын засгийн газар Чөлөөт худалдааны гэрээгээр ашиг олдог үйлдвэрүүд ХАА-н салбарыг сангаар дэмжих бодлого гаргасан ба эдгээр үйлдвэрүүдийг олсон цэвэр ашгаа ХАА-д хөрөнгө оруулалт хийхийг зөвшөөрсөн байна.

Мөн саяхан Солонгосын будаа тариалагч фермерүүд Чөлөөт худалдааны гэрээнээс болж ямар нэгэн алдагдалд орсон тохиолдолд Засгийн газраас нөхөн төлүүлдэг байхаар хэлэлцэж байна. Энэ нь Солонгосын фермерүүдээ амьдруулах нь Засгийн газрын үүрэг гэж үзэж байгаа юм байна.

Солонгосын эрчимжсэн фермерүүдийн холбоо /KAFF/ дараах бодлогуудыг санал болгож байна. Үүнд:

Фермерүүдэд технологийн болон эко системийн талаарх сургалтаар дэмжсэнээр өрхийн аж ахуй тасралтгүй үргэлжилнэ

Залуу фермерүүдийг цэргийн албанаас чөлөөлөх

Залуу фермерүүдэд одоогийн 3% хүүтэй зээлийн хүүг 1% болгож бууруулан санхүүгийн дэмжлэг үзүүлж албан ёсны хүлээн зөвшөөрөгдсөн үнэмлэх олгох

Залуу фермерүүдийн холбооны гишүүд нь Солонгосын эрчимжсэн фермерүүдийн холбоо /KAFF/-ны бүхий л үйл ажиллагаанд оролцох боломж олгох

Залуу фермерүүдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлж орон нутгийн удирдах түвшинд ажиллах чадавхитай болгох гм.

Залуучуудыг ХАА-д татахын тулд манай Засгийн газар юу хийж чадах вэ?

Бидний хөдөөгийн залуустай хийсэн ажиглалт, ярилцлагын үр дүнд дараах тохиолдолд залуучууд ХАА-д татагдана гэж үзлээ. Үүнд:

Гэр бүлээ тэжээхэд хүрэлцэхүйц хангалттай орлогыг ХАА-аас олдог бол

Газар, хөрөнгө, сургалт, тоног төхөөрөмж, зах зээл зэрэг нөөц боломжуудаар хангагддаг бол

ХАА-н салбарт ажилладагийнхаа учир утга, ач холбогдлыг ойлгодог бол

Мөн дараах санал зөвлөгөө, үйл ажиллагаануудыг хэрэгжүүлбэл олон орнууд хүнсний асуудалд өөрсдөөсөө бүрэн хамааралтай байж тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулдаг болоход залуу фермерүүдэд өөр өөрийн орныг хөдөлгөхөд нөлөөлнө. Эдгээр зөвлөмжүүд нь дээр тэмдэглэсэн санаачлагуудаас урган гарсан юм.

Залуу фермерүүдэд газар эзэмших, түрээслэх, ашиглах боломжийг 25-аас доошгүй жилээр олгох. Ийм урт хугацааны нөхцөлгүйгээр залуучууд тосгондоо газар тариалан эрхлэх сонирхолгүй байдаг.

ХАА-н салбарын тусгай болон цогц хөтөлбөр

хэрэгжүүлж сургалт, боловсрол, нэвтрүүлэх үйлчилгээ, манлайллын сургалт, зээл, технологи, ХАА-н бүтээгдэхүүн үйлвэрлэл, шаардлагатай тоног төхөөрөмж, урамшуулал зэрэг олон асуудлыг багтаасан залуу фермерүүдэд зориулсан дэмжих үйлчилгээнүүдээр хангах. ХАА-г мэргэжил гэж үзэж сургуулийн хөтөлбөрт оруулж залуу фермерүүдийг хөдөөгийн залуу үйлдвэрлэл эрхлэгч болгон сургаж, тогтвортой, экологид суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон төрөлт үйл ажиллагаа явуулдаг ХАА-н хоршоо байгуулахад анхаарах хэрэгтэй. Залуу фермерүүд бол ХАА-н хоршоодыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй гэдгийг олон нийтэд сурталчлан таниулж ялангуяа залуу эмэгтэй фермерүүдэд тусгай анхаарал тави шаардлагатай. Учир нь тэдэнд маш их боломж байгаа боловч тэд хамгийн жижиг бөгөөд чадавхижаагүй хэсэг билээ.

Залуу фермерүүд бие биенээсээ суралцах, мөн шийдвэр гаргах болон бодлого боловсруулах үйл явцад оролцох боломжоор хангах. Залуучууд өөрсөддөө хамааралтай бодлого, хөтөлбөрт оролцож хэрэгтэй байна. Өөрсдийн мэдлэг туршлагаа дотоод болон гадаад орнуудад айлчлан солилцож залуучуудад зориулсан мэдээллийн төв байгуулах.

Алслагдмал хөдөө орон нутгийн дэд бүтцийг сайжруулж тайван амгалан амьдрах нөхцөл бүрдүүлэхийн зэрэгцээ залуу фермерүүдэд зориулсан нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх

Ази номхон далайн бүсийн орнуудын фермерүүд бол өрхийн аж ахуй эрхлэгчид бөгөөд дэлхий дээр хамгийн ядуу өлсгөлөнд нэрвэгдсэн байдаг. Фермерүүдийг газар тариалангийн шинэчлэлийн бодлого болон хөдөөгийн тогтвортой хөгжил, экологийн хандлага, зах зээл ба худалдааны эрчимжсэн цогц бодлогоор дэмжсэнээр фермерүүдийн орлого нэмэгдэж улмаар тэдний өрхийн аж ахуйн талаарх үзэл бодол өөрчлөгдөнө.

ХАА-д залуусыг татахын тулд АФХ /АГА/ юу хийж чадах вэ?

1. Бодлогын нөлөөлөл:

Ихэнх Азийн орны фермерүүд бодлогын баримт бичгүүдийн талаар санаа зовдог. Шинэ чөлөөт бодлого, ХАА-н салбарын Дэлхийн худалдааны байгууллага, цаг уурын өөрчлөлт, чөлөөт худалдаа, газар булаалт, залуу болон эмэгтэй фермерүүдийн

эрх ашиг, ниймийн хамгаалал зэрэг бүсийн хэмжээний нийтлэг асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар АФХ ажиллаж чадна. АФХ-ны бүсийн фермерүүдийн холбоо фермерүүдэд ээлтэй бодлого, хөтөлбөр, дэмжлэг гаргуулахад НҮБ-ын агентлагууд болон бусад байгууллагуудыг лоббидож чадна.

2. Фермерийн байгууллагуудыг нэгтгэн холбох:

ХАА болон газрын асуудал бол улс төрийн хамааралтай асуудал бөгөөд эдгээрийг улс төрөөр л шийдэж болдог. Тиймээс ч үндэсний болон олон улсын түвшинд иргэдийн хөдөлгөөнийг өрнүүлж холбогдох Засгийн газруудыг холбох хэрэгтэй. Үүний тулд АФХ фермерийн байгууллагууд болон Иргэний нийгмийн байгууллагуудыг нэгтгэж иргэдийн хөдөлгөөнийг дэмжиж чадна.

3. Залуу фермер солилцооны хөтөлбөр:

АФХ-ны гишүүн болон бусад Иргэний нийгмийн байгууллагууд тогтвортой ХАА-н загварыг бий болгоод байна. Фермийн болон ХАА-н мэдлэг олгох, шинэ технологи, шинэ бодлого боловсруулах, залуучуудыг ХАА-д татах зэрэг асуудлаар АФХ залуу фермерүүдийн солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлж чадна.

4. Фермерийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа:

Тогтвортой өрхийн аж ахуй ба залуучуудыг ХАА-д татах асуудал нь санхүүгийн болон техникийн дэмжлэггүйгээр хэрэгжих боломжгүй юм. Тиймээс АФХ олон орны болон бүсийн түвшинд ХАА-н салбарт илүү тогтвортой үйл ажиллагаа явуулж буй фермерүүдийн байгууллага болон Иргэний нийгмийн байгууллагууд, хандивлагч, дэмжигч байгууллагуудын дунд хамтын ажиллагааг бий болгож чадна.

5. Судалгаа болон хэвлэмэл бүтээлүүд гаргах:

ХАА-н албарт судалгаа хийх, бүтээл хэвлүүлэх, өрхийн аж ахуй, залуу фермерүүдийн асуудал бол их чухал. Эдгээртэй холбоотой олон асуудлыг судлахын зэрэгцээ орон бүрийн Засгийн газар болон хандивлагч байгууллагуудтай уулзах шаардлагатай байдаг. АФХ бүсийн түвшинд судалгаа болон уулзалт зохион байгуулж, улс орны түвшинд бол энэ чиглэлээр дэмжлэг үзүүлэх боломжтой.

ДҮГНЭЛТ

Дэлхийн нийт залуучуудын 60 орчим хувь буюу 750 сая хүн Ази-Номхон далайн бүсэд амьдарч байна. Тэдний 70% буюу 525 сая нь хөдөө орон нутагт, талаас илүү хувь нь ХАА-д ажиллаж байна. Гэсэн хэдий ч олон залуучууд хот руу нүүх, эсвэл гадаадад ажиллахыг илүүд үзэж байна. Хөдөө орон нутагтаа үлдсэн залуучуудын олонхид нь ямар нэгэн илүү хувилбар байдаггүй. Тэд ХАА-д ажиллах нь эрсдэл ихтэй, орлого багатай, төрийн болон бусад байгууллагуудын дэмжлэг сул гэж боддог.

Гэсэн хэдий ч:

Гэр бүлээ тэжээхэд хүрэлцэхүйц хангалттай орлогыг ХАА-аас олдог бол

Газар, хөрөнгө, сургалт, тоног төхөөрөмж, зах зээл зэрэг нөөц боломжуудаар хангагддаг бол

ХАА-н салбарт ажилладагийнхаа учир утга, ач холбогдлыг ойлгодог бол залуучууд ХАА-д татагдах боломжтой.

Залуучуудыг ХАА-д татах, хөтлөх боломж бол хөдөөгийн тогтвортой хөгжил, экологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, газар тариаланд суурилж фермерүүд өөрсдөө зохицуулалт хийдэг үйлдвэрүүд байгуулахын зэрэгцээ худалдаа борлуулалтыг газар дээр нь шийддэг, залуучууд, ялангуяа эмэгтэйчүүдэд зориулсан тусгай хангамж, хөнгөлөлт, урамшууллын систем бий болгох зэрэг асуудлуудыг иж бүрнээр шийдвэрлэсэн өргөн хүрээтэй, цогц газар тариалангийн шинэчлэлийн бодлого боловсруулах явдал юм.

Залуучууд бол улс орны ирээдүй бөгөөд ялангуяа хөдөөгийн залуучууд бол хөдөө аж ахуй болон хөдөөгийн үйлдвэржилтийн ирээдүй юм. Бид ирээдүйдээ хоолтой байхын тулд одоо хөдлөх цаг нь иржээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

“Ази тивийн залуучуудыг ХАА-д татах нь: одоогийн байдал ба хэтийн төлөв” Азийн Фермерүүдийн холбоо, 2014 оны 12-р сар

Азийн Фермерүүдийн холбооны VI их хурал “Өрхийн аж ахуйн жилд жижиг фермерүүдийн орлогыг нэмэгдүүлэх нь” Индонези, Бали 2014.05.06-08

Азийн Фермерүүдийн холбооны Залуу фермерүүдийн бүсийн уулзалт, зөвлөгөөн “Ази тивийн залуу фермерүүдийн хөгжлийн хөтөлбөр” Филлипин, 2014.11.25-26

Ахмад Күзихоликүзаман. “Өмнөд Азийн орнуудын ХАА-н шинэчлэл болон бүтэц, хэтийн төлөвлөөс суралцахуй” Өмнөд Азийн эдийн

засгийн интеграцилал, Дели 2010

Араги.Ф.А “Дэлхийн тариачин ёсыг устгасан нь 1945-1990” АНУ-ын Социологийн судалгаа 36-р дэвтэр, 1995 он http://www.polsci.chula.ac.th/jakkrit/anthro/Rural_Sociology_files/Global%20Depeasantization.pdf 2012.10.20 337-368-р хуудас

Борас.С.М (2006). “Шинэ чөлөөт бодлогын онол ба дадлага” 2014.07.01 <http://www.foodfirst.org/files/bookstore/pdf/promisedland/5.pdf>

Харвей.Д Harvey, D. (2003). “Шинэ империализм” Лондон: Оксфордын Их сургууль

Ху. Ж. Еих.А.Бу (2009). “Газрыг тавааржуулалт: 1990-ээд оноос хойших Хятадын улс төр ба газрын хөгжил” Олон улсын сэтгүүл №33 2009.12.04 890-913-р хуудаснаа http://www.grm.cuhk.edu.hk/eng/research/RAE2011/XuJiang/2_IJURR_2009.pdf

ХАА-н хөгжлийн олон улсын сан /IFAD/ (2011). “Ирээдүй үеэ тэжээхүй: Хөдөөгийн залуу фермерүүд өнөөдөр-маргаашийн амжилт бүтээл.

PIED (2012). “Өрхийн жижиг аж ахуй эрхлэх болон хөдөөгийн хурдацтай хөгжлийн эрин үе” <http://pubs.iied.org/pdfs/14617IIED.pdf> 2015.04.07

Кумар.А (2011). “Шинэ чөлөөт үеийн газар-бараа бүтээгдэхүүн ба social good” Хот төлөвлөлтийн институт, Энэтхэг, 2011.04-06 сар 8-208 сэтгүүл http://itpi.org.in/files/apr2_11.pdf 2014.01.17

Петерс, Давид Ж. (2002) *Goldschmidt таамалалыг эргэн үзэхүй: Баруун бүсийн эдийн засгийн бүтцийн үр дүн ба нийгэм эдийн засгийн нөхцөл байдал. Миссури мужийн дийн засгийн хөгжлийн хэлтэс* P-0702-1, Жефферсон хот, Миссури мужийн дийн засгийн хөгжлийн хэлтэс (2002).

Шреста.Н (2001). Газрын улс төрийн эдийн засаг, Непал улсын цагаачлал ба газаргүйдэл. *Непал: Нирала хэвлэл*

Нэгдсэн Үндэстний сан (2011). *Түүхэн дэх залуу үеийн шийдвэрлэх мөч.* 2011.01.25 <http://www.unfoundation.org/news-and-media/press-releases/2011/largest-youth-generation-in-history-at-crossroads.html?referrer=https://> 2015.01.17

Вобст, П. (2010). Хөдөөгийн залуучуудын ажил эрхлэлт болон хувиараа аж ахуй эрхлэлтийг дэмжих: Газар тариалан ба амьдралын сургуулийн жишэ. Бруселийн хөдөөгийн хөгжлийн 19 дэх удаагийн зөвлөгөн 2010.06.16

CREDITS

Зохиогч : Жагат Баснет

Хянасан: Мари Раселис

Хянан тохиолдуулсан: Мария Жосефа Петилла, Ма. Эстрелла Пенуниа, Марсиано Вирола, Жг

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Бебс Павия, Art Angel Printshop

Зургийг: Азийн Фермерүүдийн холбооны зургийн сангаас

Азийн фермерүүдийн холбооноос Agriterra-ийн дэмжлэгтэйгээр хэвлэв.

2015 оны 6-р сар 7-р хэвлэл №1



13381 УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, ЭНХТАЙВНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ,
18А-1, УБД 63, УТАС:45-35-35, 45-86-71, ФАКС: 45-88-99
И-МЭЙЛ: info@namac.coop, info@namac.mn
Вэб: www.namac.coop